



**БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН  
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ  
КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 10 сарын 24 өдөр

Дугаар A/312

Улаанбаатар хот

Компанийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх хамрах хүрээг батлах тухай.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй”-н тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, 28.1.6 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны олон улсын ISO 45001:2018 стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх зорилгоор компанийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллах Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлогыг хавсралтаар баталсугай.

2.Компанийн хэмжээнд ISO 45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх хамрах хүрээг Төв компани болон Багануур цахилгаан түгээх сүлжээ салбарт хэрэгжүүлэхээр тогтоосугай.

3.Компанийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлогыг нийт ажилтнууд болон сонирхогч талуудад танилцуулж нийтэд нээлттэй байлгах, шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг ISO 45001:2018 Менежментийн тогтолцоо стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх ажлын хэсэг (А.Азбаяр)-т үүрэг болгосугай.


4.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтсийн дарга (Д.Цэцгээ)-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Н.МӨНГӨНХӨЛӨГТ

122421453



“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын *Д.М* оны 10 сарын 24 өдрийн *1312* тоот тушаалын хавсралт

## “БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН БОДЛОГО

“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК нь Монгол улсын хуулийн хүрээнд ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангаж, ажилчдыг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарахаас урьдчилан сэргийлж, хөдөлмөрийн чадвар алдалтгүй ажиллахыг зорино.

Компанийн ажилтнууд болон оролцогч бусад талуудтай зөвлөлдөх замаар хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал (“ХЭМАБ”)-ын менежментийн тогтолцоог нэвтрүүлж, тасралтгүй сайжруулан, аюулгүй ажиллагааны соёлыг хөгжүүлэн, төлөвшүүлэхэд бидний зорилго оршино.

Үүний тулд:

1. Компанийн ажилтнуудын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэлүүдийг үнэлж, тэдгээрийг бууруулах, хянах арга хэмжээ тогтмол авч хэрэгжүүлэх;
2. Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг дагаж мөрдөх тэдгээрийн хэрэгжилтийг биелүүлэхийн төлөө эрмэлзэн ажиллах;
3. ХАБЭА-н зорилго, зорилт болон гүйцэтгэлтэй холбоотой хариуцлагын асуудлыг байгууллагын бүх төвшинд бий болгож, мэдээллийг шуурхай солилцох;
4. Нийт ажилтнуудад аюулгүй ажиллагааны мэдлэг олгох ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөв хандлага соёлыг төлөвшүүлэх;
5. ХАБЭА-н зөрчил, үйлдвэрлэлийн ослын шууд болон суурь шалтгаануудыг тогтоож, дахин давтагдахаас сэргийлэх арга хэмжээ авч ажиллах;
6. Менежментийн тогтолцоог тасралтгүй сайжруулах зорилгоор ажлын гүйцэтгэлийн үр дүнгийн талаар тогтмол хяналт тавих, дотоод болон хөндлөнгийн аудит хийх, илэрсэн үр дүнгээр нэмэлт арга хэмжээг тус тус авч ажиллана.

ЭНЭХҮҮ БОДЛОГО НЬ БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН АЖИЛТНУУДАД БОЛОН ТҮҮНИЙ СОНИРХОГЧ ТАЛУУДАД ХАМААРАХ БӨГӨӨД НИЙТЭД НЭЭЛТТЭЙ БАЙНА.